



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН
/ЗТХЯ-ны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээ-1 р улирал/

2018.04.10

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээний зорилго, үндэслэл, арга зүй

Хяналт-шинжилгээ хийх зорилго нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтыг хангахад чиглэгдсэн арга хэмжээний гүйцэтгэлийн явцын талаар дүгнэлт гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгсний үндсэн дээр төлөвлөсөн арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэх зохион байгуулалт, зохицуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Эрх зүйн үндэслэл нь “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 42 дугаар тогтоол, “Төлөвлөгөө батлах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 52 дугаар тушаал болно. Эдгээр тогтоол, тушаалын заалтын дагуу хэрэгжүүлсэн ажлын явцад хийсэн хяналт-шинжилгээний тайлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх ба энэ нь Засгийн газраас тус яамны үйл ажиллагааг үнэлж дүгнэх нэг шалгуур үзүүлэлт болохын зэрэгцээ яамны ерөнхий менежер, нэгжийн менежерүүдийн үйл ажиллагаа, үр дүнгийн гэрээний биелэлтийн түвшинг үнэлж, дүгнэх нэг үзүүлэлт болох ач холбогдолтой.

Арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн түвшингийн хувийг тогтоохдоо Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ыг баримталсан болно.

Хоёр. Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн явц

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 42 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. Зам, тээврийн салбарт 7 зорилтыг хэрэгжүүлэх нийт 22 арга хэмжээний хэрэгжилтийг үнэллээ. Үүнд:

- Авто замын салбарт 3 зорилтыг хэрэгжүүлэх 9 арга хэмжээ
- Төмөр зам, далайн тээврийн салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 7 арга хэмжээ
- Агаарын тээврийн салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 3 арга хэмжээ
- Автотээврийн салбарт 2 зорилтыг хэрэгжүүлэх 3 арга хэмжээ

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ын дагуу Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 22 арга хэмжээний хэрэгжилтийг 2018 оны 1-р улирлын байдлаар авч үзвэл 2 арга хэмжээ үнэлэх боломжгүй байгаа ба бусад 20 арга хэмжээ **дунджаар 34 хувийн биелэлттэй** үнэлэгдлээ.


Хэрэгжилтийг давхардсан тоогоор газар, хэлтэс тус бүрээр авч үзвэл:

Хүснэгт 1

№	ГАЗАР, ХЭЛТЭС	Нийт заалт	100	70	40	0	Үнэлэх боломжгүй	Хувь
1	БТГ	-	-	-	-	1	-	0
2	АЗБХЗГ	9	-	1	7	-	1	43.7
3	АТБХЗГ	3	-	2	-	1	-	45
4	ТЗДТБХЗГ	8	-	-	2	5	1	10.2
5	АТБХЗХ	4	-	1	1	2	-	27.5
6	ХШУДАГ	7	-	1	5	-	1	45
7	ИНЕГ	2	-	1	1	-	-	55
8	"МТЗ" ТӨХК	3	-	-	1	1	1	20
9	"УБТЗ" ХНН	1	-	-	1	-	-	40
10	"Нортерн рейлвейс" ХХК	1	-	-	-	1	-	0
Нийт		22	-	4	10	6	2	34


Нийт арга хэмжээний хэрэгжилтийг газар, хэлтсээр тус бүрээр ангилж үзүүлбэл:

Зураг 1



Нийт арга хэмжээг хэрэгжилтийн хувиар үзүүлбэл:

Зураг 2



Гурав. Дүгнэлт

Хэрэгжилтийн хувьд авч үзвэл 2018 оны 1-р улирлын байдлаар тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувийн хэрэгжилттэй 4, эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувийн хэрэгжилттэй 10, хэрэгжээгүй 6, үнэлэх боломжгүй 2 арга хэмжээ байна.

Дараах шалтгааны улмаас доорх 2 арга хэмжээг үнэлэх боломжгүй гэж үзлээ. Үүнд:

Хүснэгт 2

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт
6.4.3.	Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын барилгын ажлыг дуусгах Барилгын ажлын явц, 100 хувь	ТЗДТБХЗГ, “МТЗ” ТӨХК: Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын царигийн өргөний хэмжээг Улсын Их Хурлын 2014 оны “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 64 дүгээр тогтоолын 1 дэх заалтад нэмэлт оруулахаар УИХ, Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг бэлтгэн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2017 оны 12 дугаар сард хүргүүлсэн. Одоогийн байдлаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээгүй, хүлээгдэж байна. Тус чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх асуудал нь “Ар Ди Си Си” ХХК-ийн барьж байгуулсан Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай авто замын “барих-ашиглах-шилжүүлэх” концессын гэрээний холбогдох зүйл, заалттай зөрчилдөн шүүх байгууллагад шалгагдаж байгаа тул уг төмөр замын төслийн ажил зогсонги байдалтай байна.
6.7.1.	“Хүйтний хөндий” дэх засварын ажлыг гүйцэтгэх Үйл ажиллагааны хэрэгжилт, 100 хувь	АЗБХЗГ, ХШУДАГ: Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 371-431 км хооронд Хүйтний хөндийн 60 км авто замын их засвар, шинэчлэлтийн ажлын зураг төслийг боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг зарласан. Тус яамнаас их засвар, шинэчлэлтийн ажлын хөрөнгө батлуулахаар 2017, 2018 оны Улсын төсвийн төсөлд санал хүргүүлсэн боловч хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй байна



Дараах 40 хувийн биелэлттэй 10, хэрэгжээгүй 6 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэллээ. Үүнд:

Хүснэгт 3

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт
6.1.2.	Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга	АТБХЗХ: Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 33 дугаар тушаалаар “Иргэний нисэхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. “Иргэний нисэхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг 2018.03.13-ны өдөр уулзалт хийсэн. Мөн Иргэний нисэхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлгэхээр зөвлөх үйлчилгээ авахаар гэрээ байгуулж байна. Хууль тогтоомжийн үр нөлөөг судлах, үр нөлөөг үнэлэх, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зэрэг ажлууд хийгдэж байна. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг боловсруулах шатанд байна. Хэрэгжилт-0
6.1.3.	Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга	ТЗДТБХЗГ: Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017.06.07-ны 115 дугаар тушаалаар байгуулагдсан Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төслийг боловсруулж 2018.02.26-ны 08/806 дугаар албан бичгээр харьяа байгууллагуудаас санал авч тусган, 2018.03.23-нд салбарын хүрээнд хэлэлцүүлэг хийсэн. Үзэл баримтлалыг Сайдын Зөвлөлийн хуралдаанд оруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамаар батлуулахаар ажиллаж байна. Хэрэгжилт-0
6.4.1.	Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлэх Барилгын ажлын явц, 70 хувь	ТЗДТБХЗГ: Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 04 дүгээр сард БНХАУ-д хийх айлчлалын бэлтгэл ажлыг хангах, тээврийн салбарт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ 2018 оны 01 дүгээр сард БНХАУ-д айлчилсан. Айлчлалын үеэр Хятадын Тээврийн яамтай Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх чиглэлд хамтран ажиллах асуудлыг хэлэлцэж, Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замын холболтын цэгийг тохиролцох чиглэлд үргэлжлүүлэн хамтран ажиллахаар тохиролцсон. Энэ оны 04 дүгээр сарын Ерөнхий сайдын айлчлалын үеэр уг төмөр замын асуудлаар Хятадын талтай хэлэлцээг үргэлжлүүлэхээр төлөвлөж байна. Хэрэгжилт-0
6.4.2.	Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх Барилгын ажлын явц, 20 хувь	ТЗДТБХЗГ, “МТЗ” ТӨХК: Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төсөл нь Монгол-Орос-Хятадын “Эдийн засгийн коридор” хөтөлбөрийн Төмөр замын зүүн коридор байгуулах төсөлд багтсан. Эдийн засгийн коридорыг хөгжүүлэх хүрээнд “Төмөр замын зүүн коридор-бүс нутаг ба уул уурхайн хөгжил” олон улсын зөвлөлдөх уулзалтыг 2018 оны 1 дүгээр сарын 22, 23-ны өдөр Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан. Зөвлөлдөх уулзалтын үеэр талууд төмөр замын зүүн коридороор тээвэрлэх ачаа эргэлт хангалттай бий бөгөөд Забайкальскийкийн төмөр замын ачааг хуваалцах нөхцөл байдал үүсэхгүй гэж үзсэн. “Монголын төмөр зам” ТӨХК нь Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулахаар БНХАУ-ын “Башинь төмөр зам” ХХК-тай санамж бичиг байгуулж ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг “Башинь төмөр зам” ХХК-ийн санхүүжилтээр Хятадын Төмөр замын зураг төслийн гуравдугаар хүрээлэн гүйцэтгэсэн. Тус ТЭЗҮ үр ашиг багатай гарсан тул Хөөт орчимд нүүрс боловсруулах, нүүрснээс хий, шингэн түлш гаргах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах аж үйлдвэрийн парк

		байгуулж төмөр замтай уялдуулан цогцоор нь хөгжүүлэх, ачааны эх үүсвэрийг нэмэгдүүлж ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулж байна. ТЭЗҮ бэлэн болмогц зураг төслийг боловсруулна. Хэрэгжилт-0
6.4.6.	Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх Барилгын ажлын явц, 30 хувь	ТЗДТБХЗГ, Концесс эзэмшигч: "Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" нөхцөлтэй концессоор хэрэгжиж буй Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын төслийн концесс эзэмшигч "Нортерн Рэйлвэйс" ХХК нь уг төмөр замын төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг гүйцэтгүүлэх, цаашид хамтран ажиллахаар БНХАУ-ын Чайна гэжуба групп корпорацитай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Санамж бичгийн дагуу Чайна гэжуба групп корпораци нь тус төмөр замын төслийн олон улсын банк, санхүүгийн байгууллагын шаардлага хангасан ТЭЗҮ-ийг боловсруулж дуусаад байна. Одоогийн байдлаар ТЭЗҮ-г хянах, тодруулга авах, санал солилцох ажил хийгдэж байна. Төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг шийдвэрлэснээр 2019 онд төмөр замын барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна. Хэрэгжилт-0
6.5.1.	Хөшигийн хөндийн тээвэр, логистикийн төв байгуулах Барилгын ажлын явц, 30 хувь	БТГ, ТЗДТБХЗГ, АТБХЗГ, АТБХЗХ: Богдхан төмөр зам, Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төв байгуулахаар АХБ-тай Зам, тээврийн яам /хуучин нэрээр/ 2014 оны 10 дугаар сард санамж бичиг байгуулсан. Богдхан төмөр замын чигийн судалгааг 2017 онд АХБ-ны техникийн туслалцаагаар гүйцэтгэсэн. Богдхан төмөр замын трасс батлагдсны дараа Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төв байгуулах ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор АХБ-ны 2018-2020 онд Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөнд тусгуулах саналыг 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 04/777 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлээд байна. Хэрэгжилт-0
6.2.1.1.	Ховд-Өлгий чиглэлийн 103.9 км хатуу хучилттай авто замыг барих	АЗБХЗГ, ХШУДАГ: "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд АХБ-ны 3129-МОН зээлийн хөрөнгөөр хэрэгжих Ховд-Өлгий чиглэлийн 103.9 км авто замын барилгын ажлыг 2 багц хэсгээр зохион байгуулан хэрэгжүүлж байна. Зам барилгын ажлын гэрээг багц тус бүрээр 2015 оны 08 дугаар сард байгуулсан. Багц 1, 2 хэсгийн барилгын ажил 2016 оны 05 дугаар сард эхэлсэн. Гэрээний дагуу дээрх багц хэсгүүдийн барилгын ажлыг 2018 оны 08 дугаар сарын 30-нд дуусгаж ашиглалтад оруулна. Багц тус бүрээр авч үзвэл: - Багц-1 буюу Хашаатын даваа-Шурагийн гүүр чиглэлийн 50 км хатуу хучилттай зам барилгын ажил 55%-тай явагдаж байна. Үүнээс хөрс хуулалт-100%, далангийн дүүргэлт-100%, ухмал-100%, хөлдөлтөөс хамгаалах үе-100%, суурь-53%, хучилт-31%, хөвөө-30% тус тус хийгдсэн. - Багц-2 буюу Шурагийн гүүр-Ховд чиглэлийн 53.9 км хатуу хучилттай зам барилгын ажил 65%-тай явагдаж байна. Үүнээс хөрс хуулалт-100%, далангийн дүүргэлт-100%, ухмал-100%, хөлдөлтөөс хамгаалах үе-93%, суурь-80%, хучилт-80%, хөвөө-80% тус тус хийгдсэн. 2018 оны барилгын ажлыг эхлүүлэхэд шаардлагатай бэлтгэл ажлыг хангах хүрээнд гадаадаас ажиллах хүч авах зөвшөөрлийг ЗГ-ын 2018.03.14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. Мөн барилгын ажлын нарийвчилсан график төлөвлөгөөг гарган батлуулсан. Хэрэгжилт-40%
6.2.1.2.	Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто замыг барих	АЗБХЗГ, ХШУДАГ: Тус авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын "Шанхай Констракшн Групп" компани шалгарч 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр нийт 56,785,696.10 ам.долларын ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан бөгөөд 2018 онд авто замын барилгын ажлыг бүрэн дуусгана. Талбай дээр хөрс хуулалт 100%, далангийн дүүргэлт 96%, суурийн ажил 20%, гүүрийн ажил 28%, хиймэл байгууламжийн ажил 61% тус тус хийгдээд байна. Нийт ажлын явц 39.07%-тай байна. Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авч ажиллуулах 350 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2018.03.14-ний өдрийн 72 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Гүйцэтгэгч компани 2018 онд

		хийж гүйцэтгэх барилга угсралтын ажлын нарийвчилсан график төлөвлөгөөгөө захиалагчаар батлуулсан бөгөөд батлагдсан график төлөвлөгөөний дагуу 2018.04.01-ний өдөр барилгын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Хэрэгжилт-40%
6.2.1.3.	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто замыг барих	АЗБХЗГ, ХШҮДАГ: Тус авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Шинжиан Бэйшин Роуд энд Бридж Групп” компани шалгарч 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр нийт 42,198,856.39 ам.долларын ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан бөгөөд 2018 онд авто замын барилгын ажлыг бүрэн дуусгана. Талбай дээр хөрс хуулалт 96%, далангийн дүүргэлт 89%, суурийн ажил 50%, гүүрийн ажил 100%, хиймэл байгууламжийн ажил 70%, хучилтын ажил 50% тус тус хийгдээд байна. Нийт ажлын явц 59%-тай байна. Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авч ажиллуулах 138 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2018.02.06-ны өдрийн 45 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Гүйцэтгэгч компани 2018 онд хийж гүйцэтгэх барилга угсралтын ажлын нарийвчилсан график төлөвлөгөөгөө захиалагчаар батлуулсан бөгөөд батлагдсан график төлөвлөгөөний дагуу 2018.04.15-ны өдөр барилгын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Хэрэгжилт-40%
6.2.1.4.	Олон улсын шинэ нисэх онгоцны буудал-Улаанбаатар чиглэлийн 32.2 км хатуу хучилттай авто замыг барьж дуусгах	АЗБХЗГ, ХШҮДАГ: Улаанбаатар-Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн 32.226 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Төмөр замын 4-р групп” компани шалгарч 2015 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр нийт 140,335,893.00 ам.долларын барилгын ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан. Хяналтын зөвлөхөөр БНХАУ-ын “Гуанжоу Ванан Констракшн Супервишн” компани шалгарч 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдөр 7,207,921.00 ам.долларын зөвлөхийн үйлчилгээний гэрээг байгуулан ажиллаж байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар авто замын замын далангийн ажил 98%, хиймэл байгууламжийн ажил 94%, буталсан чулуун болон цементээр бэхжүүлсэн суурь ажил 49% тус тус хийгдсэн байна. Нийт 6 гүүр баригдахаас 4 гүүрийн барилгын ажил дууссан, 2 гүүрийн ажил 88%-тай, 20 дөрвөлжин хоолой баригдахаас 15 хоолойны ажил дууссан, 5 хоолойны ажил 10-80%-ийн гүйцэтгэлтэй, 28 дугуй хоолой баригдахаас 23 хоолойны ажил дуусч, 5 хоолойны ажил 10-82%-ийн гүйцэтгэлтэй байна. Нийт ажлын явц 54.2%-тай байна. Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авч ажиллуулах 138 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2018.02.06-ны өдрийн 45 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Гүйцэтгэгч компани 2018 онд хийж гүйцэтгэх барилга угсралтын ажлын нарийвчилсан график төлөвлөгөөгөө захиалагчаар батлуулсан бөгөөд батлагдсан график төлөвлөгөөний дагуу 2018.04.15-ны өдөр барилгын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Хэрэгжилт-40%
6.2.2.	Улсын чанартай авто зам, замын байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцлийг хангах Ажлын явц 100 хувь	АЗБХЗГ, ХШҮДАГ: Улсын төсөвт олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажилд 20.0 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд замын чиглэл, хариуцагч компани бүрээр хучилтын төрөл, насжилт, хөдөлгөөний эрчимтэй уялдуулан 2018 оны төлөвлөгөөг гаргаж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 38 дугаар тушаалаар батлуулан төрийн өмчит 20, хувийн хэвшлийн 7, нийт 27 зам хариуцагч компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. Сайдын тушаалаар батлагдсан нийт 48 цэгт өвлийн арчлалтын “Шуурхай ажлын хэсэг” гарч улсын чанартай авто зам, замын байгууламжийн өдөр тутмын байнгын бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Хэрэгжилт-40%
6.3.1.	Баянзүрх болон Сонсголонгийн гүүрийн барилгын ажлыг эхлүүлэх явц, хувиар Барилгын ажлын явц,	АЗБХЗГ: Төслийн гүйцэтгэгч Бээжин Юни-Констракшн Групп компанитай 2016.07.18-ны өдөр барилгын ажлын гэрээг, 2017.04.17-ны өдөр “Гуанжоу Ванан Констракшн Супервишн” ХХК-тай хяналтын зөвлөх үйлчилгээний гэрээг тус тус байгуулсан. Төслийн нийт өртөг 21,4 сая ам.доллар. Хэрэгжүүлэх хугацаа 22 сар. Төслийн урьдчилгаа төлбөрийн хүсэлтийг Сангийн яамнаас Хятадын Эксим банкинд хүргүүлээд байна. Төслийн урьдчилгаа төлбөр шийдвэрлэгдсэнээр барилгын ажил эхлэх

	30 хувь	<p>бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд ажилчдын түр байр барих, барилгын ажлын талбайг байгуулах, Засгийн газрын 2018 оны 45 дугаар тогтоолоор гүйцэтгэгчийн гадаадаас авах ажиллах хүчин, мэргэжилтнийг баталсны дагуу эхний ээлжийн ажиллах хүчнийг ирүүлэх зэрэг ажлыг зохион байгуулаад байна. Төслийн газар чөлөөлөлтийн ажлын хүрээнд НЗД-ын 2018 оны А/194 дүгээр захирамжийн дагуу Баянзүрхийн гүүрийн трасст орсон мод, бургасыг зайлуулж талбай чөлөөлөх ажлыг хэрэгжүүлэн, нөхөн олговорт 48,88 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Хэрэгжилт-40%</p>
6.3.2.	<p>Яармагийн гүүрийн барилгын ажлыг эхлүүлэх</p> <p>Барилгын ажлын явц, 20 хувь</p>	<p>АЗБХЗГ: Төслийн гүйцэтгэгч “Хятадын төмөр замын 20-р товчоо групп” корпораци төслийн зураг төсөв боловсруулах болон барилгын ажлыг гүйцэтгэнэ. Төслийн нийт өртөг 30,26 сая ам.доллар, хэрэгжүүлэх хугацаа 2016.10.01- 2019.01.30.</p> <p>Төслийн барилгын ажлыг үргэлжлүүлэх бэлтгэл ажил хангаж байна. Тус ажлын хүрээнд Засгийн газрын 2018 оны 45 дугаар тогтоолоор гүйцэтгэгчийн гадаадаас авах ажиллах хүчин, мэргэжилтнийг баталсны дагуу ажиллах хүчин, мэргэжилтнийг ирүүлэх, техник тоног төхөөрөмж, машин механизмийн бэлэн байдлыг хангах ажлууд хийгдэж байна. Барилгын ажлыг 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэхээр ажиллаж байна. Хэрэгжилт-40%</p>
6.4.4.	<p>Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх</p> <p>Барилгын ажлын явц, 10 хувь</p>	<p>ТЗДТБХЗГ, “МТЗ” ТӨХК: Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын суурь бүтцийн чиглэл, барих үе шат, уртыг Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д нэмэлтээр тусгахаар Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Иймд Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын царигийн өргөний хэмжээг тогтоолгохоор өмнө нь УИХ-д өргөн барьсан УИХ-ын тогтоолын төслийг Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлээр эгүүлэн татсан.</p> <p>Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-г боловсруулах чиглэлээр “Монголын төмөр зам” ТӨХК, БНХАУ-ын “Си Ар И Си” компани хооронд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан ТЭЗҮ-ийг боловсруулсан бөгөөд Монгол хэл рүү орчуулах ажил хийгдэж дууссан.</p> <p>Төмөр замын зураг төсөл боловсруулах санхүүжилтийг шийдвэрлэснээр зураг төслийг боловсруулна. Хэрэгжилт-40%</p>
6.4.5.	<p>“Богдхан” төмөр замын трассыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулан барилгын ажлыг эхлүүлэх</p> <p>Барилгын ажлын явц, 20 хувь</p>	<p>ТЗДТБХЗГ, “УБТЗ” ХНН: Зам, тээврийн хөгжлийн яам (хуучин нэрээр), Азийн хөгжлийн банк хооронд 2014 онд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд АХБ-ны техникийн туслалцаагаар Богдхан төмөр замын чигийн судалгааны ажлыг “Ай Си Ти Интернэшнл” ХХК тэргүүтэй түншлэл гүйцэтгэсэн.</p> <p>Үлдэгдэл техникийн туслалцааны хүрээнд уг төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах санхүүжилтийг АХБ-ны 2018-2020 оны Монгол улс дахь үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөнд тусгуулах саналыг СЯ руу хүргүүлээд байна.</p> <p>Мөн ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга АХБ-ны төлөөлөлтэй 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдөр уулзаж АХБ-наас үзүүлж буй техникийн туслалцааны төслийг цаашид үргэлжлүүлэн “Богдхан” төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэх саналыг тавиад байна.</p> <p>Хэрэгжилт-40%</p>
6.6.2.	<p>Хэнтий аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх</p> <p>Ажлын явц, 30 хувь</p>	<p>АТБХЗХ, ИНЕГ: Хэнтий аймаг дахь Нисэх буудлын аэродромын зураг төсвийг 2017 оны 01 дүгээр сарын 31, барилгын зураг төсвийг 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдөр улсын экспертизээр батлуулж, Хэнтий аймгийн Засаг дарга Н.Ганбямбад 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдөр хүлээлгэн өгсөн. Баримт бичгийг 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Кувейтын талд хүргүүлсэн бөгөөд хөрөнгө оруулагчийн хариу шийдвэрийг хүлээж байна.</p> <p>Кувейтийн талаас аль эх үүсвэрээс санхүүжүүлэх тухай албажуулсан мэдээгээ ирүүлээгүй байна. Хэрэгжилт-40%</p>

4. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2018 оны 1-р улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Улсын Их Хурлын 2017 оны 42 дугаар тогтоол батлагдсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт 1 дүгээр улирлын байдлаар 30.6%-тай, 6 арга хэмжээ 0 хувьтай. 10 арга хэмжээ 40 хувьтай хангалтгүй дүгнэгдэж байгаа тул 2018 онд хүрэх түвшин, үр дүн, шалгуур үзүүлэлтэд хүргэхэд онцгой анхаарч ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, хэлтсүүдэд;

2. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.6-д “Бодлогын зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2 удаагийн тайлангийн хугацаанд дараалан ахиц гараагүй бол УДААШИРСАН, 3 удаагийн тайлангийн хугацаанд мөн ахиц гараагүй бол ТАСАРСАН-д тооцно” гэж заасан тул Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд үргэлжлүүлэн тусгагдсан арга хэмжээнүүдийг 2017 оны хагас, бүтэн жилийн хэрэгжилтээс ахиулж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, хэлтсүүдэд;

4. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд төмөр замын салбарт хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ/*Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, 60 хувь, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, 10 хувь, Шивээхүрэн-Сэхэ чиглэлийн боомтын төмөр замын барилгын ажлын явц, 100 хувь, Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, 20 хувь, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилтийн явц, 10 хувь, Богдхан төмөр замын төслийн хэрэгжилтийн явц, 10 хувь*-ний хэрэгжилт Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 0 хувьтай дүгнэгдсэн бөгөөд тус арга хэмжээнүүд Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгагдсан байх тул хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээг эрчимтэй авч хэрэгжүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газар, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт тус тус зөвлөж байна.

Танилцсан:

Сайд	Ж.Бат-Эрдэнэ
Төрийн нарийн бичгийн дарга	Ж.Бат-Эрдэнэ
Төрийн захиргааны удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Махбал
Бодлого, төлөвлөлтийн газрын дарга	Р.Мэргэн
Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Д.Доржханд



Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга С.Батболд

Төмөр зам, далайн тээврийн бодлогын
хэрэгжилтийг зохицуулах
газрын дарга Б.Артур

Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах хэлтсийн дарга С.Мөнхнасан

Хянасан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч Т.Гомбосүрэн

Боловсруулсан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын ахлах мэргэжилтэн Н.Буянт